



МОНГОЛ УЛСЫН  
БАЙГАЛЬ ОРЧИН,  
НОГООН ХӨГЖЛИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2014 оны 03 сарын 16 өдөр

Дугаар А-81

Улаанбаатар хот

Байгаль орчны мэдээллийн сангийн  
удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах  
журмыг шинэчлэн батлах тухай

"Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль",  
"Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 37 дугаар зүйл, 38 дугаар зүйлийн 1  
дэх хэсгийг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 7 дугаар бүлэг, Засгийн газрын  
2010 оны 85 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчны мэдээллийн санг  
бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах" журмыг  
хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий "Байгаль орчны мэдээллийн  
сангийн удирдах зөвлөл"-ийг дараах албан тушаалын бүрэлдэхүүнтэйгээр  
байгуулсугай. Үүнд:

Удирдах зөвлөлийн дарга	Төрийн нарийн бичгийн дарга
Удирдах зөвлөлийн дэд дарга	Байгаль орчны мэдээллийн төвийн захирал
Нарийн бичгийн дарга:	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын Салбарын мэдээллийн сангийн нэгдсэн удирдлага зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
Гишүүд:	Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын дарга Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга Цаг уур, орчны шинжилгээний газрын дэд дарга Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын Орон зайн мэдээлэл, технологийн хэлтсийн дарга

00203

Ашигт малтмалын газрын Кадастрын хэлтсийн дарга

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас хамгаалах газрын шуурхай удирдлага зохицуулалтын хэлтсийн байгаль, цаг уур, экологийн асуудал хариуцсан мэргэжилтэн

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, аялал жуулчлал, геологи уул уурхайн хяналтын газрын орлогч дарга

Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх газрын Эрүүгийн цагдаагийн газрын Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн дарга

Биологийн хүрээлэнгийн захирал

Ботаникийн хүрээлэнгийн захирал

Геоэкологийн хүрээлэнгийн захирал

Монголын байгаль орчны иргэний зөвлөлийн тэргүүн

2. "Байгаль орчны мэдээллийн сангийн удирдах зөвлөл"-ийн ажиллах журмыг 1 дүгээр, "Байгаль орчны мэдээллийн нэгдсэн санд төвлөрүүлэх мэдээллийн төрөл, хугацаа, хариуцах байгууллагын жагсаалт"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

3. Энэ тушаалын 2 дугаар хавсралтад заасан өөрийн байгууллагад хамаарах мэдээллийг Байгаль орчны мэдээллийн санд хугацаанд нь төвлөрүүлж байхыг ажлын хэсгийн бүрэлдэхүүнд, мэдээллийн сан бүрдүүлэх, баяжуулах, шинэчлэх, түгээх үйл явцад байнгын хяналт тавьж ажиллахыг тус яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч М.Төрбаярд үүрэг болгосугай.

4. Байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааг удирдлагаар хангаж, тухайн жилийн ажлын үр дүнг жил бүр Сайдын зөвлөлийн хуралд танилцуулж байхыг Удирдах зөвлөлийн даргад даалгасугай.

5. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Байгаль орчны мэдээллийн сангийн удирдах зөвлөл байгуулах тухай" Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2011 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн А-446 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД



С.ОЮУН

Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2014 оны 03 дугаар сарын 31 ны өдрийн  
А.8/1 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

### 1. Удирдах зөвлөлийн зохион байгуулалт

1.1. Энэхүү журмын зорилго нь Байгаль орчны мэдээллийн сангийн удирдах зөвлөл (Цаашид "Удирдах зөвлөл" гэх) -ийн үйл ажиллагааг зохицуулахад оршино.

1.2. Удирдах зөвлөл нь "Байгаль орчныг хамгаалах тухай хууль"-ийн 7 дугаар бүлэг, "Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль", Засгийн газрын 2010 оны 85 дугаар тогтоолоор баталсан "Байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, боловсруулах, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах" журмыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилготой.

1.3. Удирдах зөвлөл нь орон тооны бус байна.

1.4. Удирдах зөвлөлийн дарга, бүрэлдэхүүн, ажиллах журмыг Байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

1.5. Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд байгаль орчны мэдээллийн сан (Цаашид мэдээллийн нэгдсэн сан гэх)-д Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 37 дугаар зүйлд заасан мэдээлэл төвлөрүүлэх үүрэг бүхий байгууллагын төлөөллийг оролцуулна.

1.6. Иргэдийн мэдээлэл авах эрхийг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг Удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд оруулж болно.

1.7. Шаардлагатай гэж үзвэл удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулж болно.

### 2. Удирдах зөвлөлийн чиг үүрэг

2.1. Удирдах зөвлөл энэ журмын 1.2-д заасан зорилгынхоо хүрээнд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

2.1.1. Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл төвлөрүүлэх, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалах үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах;

2.1.2. Мэдээллийн нэгдсэн санд төвлөрсөн мэдээллийг холбогдох хуульд заасан журмын дагуу ил тод, нээлттэй болгох ажлыг зохион байгуулах, ингэснээр иргэн, хуулийн этгээд, шийдвэр гаргагчдыг мэдээллээр хангах нөхцөлийг бүрдүүлэх;

2.1.3. Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, түгээх, ашиглах, хадгалах, хамгаалахтай холбоотой асуудлаар зөвлөмж гаргах, холбогдох байгууллага, албан тушаалтанд удирдамж чиглэл өгөх;

2.1.4. Мэдээллийн сангийн дизайн, нэгдсэн арга зүй, техник, сүлжээ, программ хангамжийн шийдлийг хэлэлцэх;

2.1.5. Шаардлагатай асуудлаар төсөл хэрэгжүүлэх, судалгаа мониторинг хийлгэх, үүнтэй холбоотой ажлын хэсэг байгуулж удирдамж чиглэлээр хангах, тэдгээрийн үр дүнг хэлэлцэх, хүлээн авах, яамны удирдлагад танилцуулах;

2.1.6. Мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаатай холбоотой сургалт, семинар уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулах;

2.1.7. Мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагааг сайжруулах, удирдлага зохион байгуулалтыг бэхжүүлэх, энэ журамд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотой асуудлаар санал боловсруулж эрх бүхий байгууллага, албан тушаалтанд танилцуулах, хүргүүлэх, шийдвэрлүүлэх.

### **3. Удирдах зөвлөлийн ажиллах журам**

3.1. Удирдах зөвлөл (Цаашид Зөвлөл гэх)-ийн ажиллах хэлбэр нь Зөвлөлийн хуралдаан байна.

3.2. Зөвлөлийн хуралдааныг Зөвлөлийн дарга удирдах ба даргын эзгүйд түүний зөвшөөрснөөр аль нэг гишүүн хуралдааныг удирдан явуулж болно.

3.3. Зөвлөл улиралд нэгээс доошгүй удаа хуралдах ба Зөвлөлийн хурлын тов, хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн дарга тогтооно. Шаардлагатай тохиолдолд Зөвлөлийн дарга Зөвлөлийн хурлыг хэдийд ч зарлан хуралдуулж болно.

3.4. Зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан зохион байгуулж, хурлын товыг гишүүдэд мэдээлнэ.

3.5. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хурал болохоос 3 хоногийн өмнө гишүүдэд цахим шуудангаар хүргүүлсэн байна.

3.6. Зөвлөл ажлаа жилээр болон тодорхой хугацаагаар төлөвлөж, хагас бүтэн жилээр дүгнэнэ. Мэдээллийн сангийн ажлын явц, үр дүнг Зөвлөлийн дарга яамны удирдлагад тухай бүр танилцуулж, тухайн жилийн ажлын үр дүнг жил бүр Сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлнэ.

#### 4. Зөвлөлийн хуралдааны шийдвэр

4.1. Зөвлөлийн хуралдааны шийдвэр нь тогтоол, тэмдэглэл хэлбэртэй байна. Зөвлөлийн хуралдааны тогтоол, тэмдэглэлийг албажуулах, хөтлөх үүргийг Зөвлөлийн нарийн бичгийн дарга хариуцан гүйцэтгэнэ.

4.2. Зөвлөлийн гишүүдийн олонхи оролцсоноор Зөвлөлийн хурал хүчин төгөлдөр болох ба хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.

4.3. Хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд оролцох боломжгүй гишүүн саналаа урьдчилан өгч болох ба уг саналыг санал хураалтанд оролцуулан тооцно. Хэрэв аль нэг гишүүн тухайн хуралд оролцохоос зориуд татгалзсан буюу хэлэлцэхээр товлогдсон тодорхой асуудлыг хүлээн зөвшөөрөөгүй бол түүнийг эсрэг санал өгсөнөөр тооцож, хурлын шийдвэрийг гаргана.

4.4. Шаардлагатай гэж үзвэл Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцсэн асуудалтай холбогдуулан Зөвлөмж гаргаж болох ба түүнийг үндэслэн тус яамны Сайд, Төрийн нарийн бичгийн дарга эрх хэмжээнийхээ хүрээнд холбогдох шийдвэр гаргаж болно.

4.5. Зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалтай ажил үүргийн холбоо бүхий ажилтнуудыг хуралдаанд оролцуулан санал, дүгнэлтийг нь сонсож болно.

4.6. Зөвлөлийн гишүүд хамтын зарчмаар шийдвэр гаргах ба гаргасан шийдвэрийн талаар хамтын хариуцлага хүлээнэ.

4.7. Зөвлөлийн хуралдаанаас гарсан шийдвэрийн биелэлтийг холбогдох байгууллага, албан тушаалтан нь тогтоосон хугацаанд Зөвлөлд мэдээлэх, тайлагнах үүрэгтэй байна.

4.8. Зөвлөлийн гишүүдийн идэвхи оролцоо, энэ чиглэлийн ажилд оруулсан хувь нэмэр, зарцуулсан цаг хугацааг харгалзан зохих урамшуулал олгох эсэх болон хуралдаан зохион байуулахтай холбогдон гарах зардлыг холбогдох эх үүсвэрээс санхүүжүүлэх асуудлыг Зөвлөлийн дарга хариуцна.

**БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНД  
ТӨВЛӨРҮҮЛЭХ МЭДЭЭЛЛИЙН ТӨРӨЛ, ХУГАЦАА, ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГЫН ЖАГСАЛТ**



Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын  
2014 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн  
А.Н. Дугаар тушаалын 2 дугаар хавсралт

№	Мэдээллийн дэд сангийн нэр /БОХТухай хууль/	Эх мэдээний дэлгэрэнгүй жагсаалт /ЭГ-ын 85-р тогтоол/	Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл төвлөрүүлэх хугацаа	Хариуцах байгууллага
1	Газар, түүний хөрс	Улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн тоон болон зураг талбайн хэмжээ Газрын нэгдмэл сангийн ангиллаар газар нутгийн хэмжээ Хөдөө аж ахуйн газар Хот, суурингийн газар Зам, шугам сүлжээний газар Ойн сан бүхий газар Усан сан бүхий газар Улсын тусгай хэрэгцээний газар Доройтож талхлагдсан газар Геологийн судалгааны ерөнхий мэдээлэл	2-р сарын 20	Барилга байгуулалтын хот Газрын харилцаа, геодези, зураг зүйн газар
2	Газрын хэвлий, ашигт малтмал	Ашигт малтмалын хайгуул, олборлолт явуулж байгаа хуулийн этгээдийн талаархи мэдээлэл Иргэн, хуулийн этгээдийн ашиглаж байгаа газрын хэвлийн кадастрын зураг Газрын хэвлийн нөхөн сэргээлт Газар доорхи барилга, байгууламж Гол мөрөн, горхи, булаг шанд, нуур, цөөрөм, тойром, баян бүрдийн тоо	3-р сарын 1	Ашигт малтмалын газар, Аймаг, Нийслэлийн засаг дарга
			12-р сарын 20	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам НХБТГ

3	Ус, рашаан	<p>Намгархаг усан орчны талбай</p> <p>Улсын чанартай рашааны төрөл тоо</p> <p>Орон нутгийн чанартай рашаан, сувиллын газрын тоо</p> <p>Гадаргын болон газар доорхи усны нөөц, чанар, байршил, тэдгээрийн өөрчлөлтийн талаархи хайгуул судалгааны дүн</p> <p>Ус, рашааны тойм болон бусад зураг</p> <p>Рашаан, эрдэст нуур, эмчилгээний шаврын нөөц, чанар, найрлага, тэдгээрийн өөрчлөлт, ашиглалттай холбогдсон судалгааны дүн</p> <p>Бохирдсон ус, рашааны нэр, байршил, түүний усны нөөц</p> <p>Үер, усны хор хөнөөлийн дүн мэдээ</p> <p>Усны нөөц ашиглагч иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, төлбөр, хураамжийн орлого</p> <p>Усны нөөц ашиглалт, хаягдал усны хэмжээ, найрлага, ус ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхтэй холбогдол бүхий барилга байгууламж, тоног, төхөөрөмжийн тоо, хүчин чадал</p> <p>Усан замын тээврийн хэрэгслийн бүртгэл, төлбөр, орлого</p> <p>Ойн сан бүхий газрын талбай</p> <p>Ойгоор бүрхэгдсэн газрын талбай</p> <p>Мод уржүүлгийн тарьц, суулгац бойжуулах газар</p> <p>Ойн цоорхой</p> <p>Ойн захаас гадагш</p> <p>100 метрт орох бүсийн талбайн хэмжээ</p> <p>Модыг огтолсон талбай</p> <p>Ойн нөөц, бүрэлдэхүүн, тэдгээрийн өөрчлөлт</p> <p>Ойн тойм болон тархацын зураг</p> <p>Ойн түймрийн тоо, түймэрт нэрвэгдсэн талбайн хэмжээ, зураг.</p> <p>Ойн хөнөөлт шавьжийн төрөл зүйл, тархалт, түүнд нэрвэгдсэн ойн талбай</p>	Геоэкологийн хүрээлэн
4	Ой	<p>12-р сарын 20</p>	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яам БХЭГ</p> <p>Ой судалгаа хөгжлийн төв УТГГазар</p>

	<p>Ойн арчилгаа, цэвэрлэгээний ажлын тоо, хэмжээ Ойн нөхөн сэргээлт, Байгалийн сэргэн ургалтад туслас арга хэмжээ, ойжуулсан талбай, тарьж суулгасан мод, сөөгний төрөл, тоо хэмжээ Ирсэн, хуулийн этгээдэд гэрээгээр эзэмшүүлсэн ойн талбай Ойгоос бэлтгэж ашигласан түлшний модны хэмжээ, түүний төлбөрийн орлого</p>		
<p>5 Байгалийн ургамал</p>	<p>Ургамлын аймгийн сан, түүний ангилал Гуурст ургамал, түүний зүйлийн бүрэлдэхүүн Нэн ховор, ховор, элбэг, үлдвэр, ургамлын тархац, нөөцийн хэмжээ, түүний үнэлгээ, тэдгээрийн нэрсийн жагсаалт Усны ургамлын тархац, нөөцийн хэмжээ Хөвдгийн тархац, нөөцийн хэмжээ Замагны тархац, нөөцийн хэмжээ Мөөгний тархац, нөөцийн хэмжээ Ургамлын судалгааны дүн мэдээ Ургамлын хяналт-шинжилгээ, ажиглалт, хэмжилтийн дүн мэдээ Ургамал ашигласны төлбөр тооцох үзүүлэлт, төлбөрийн хэмжээ Хүнс, тэжээл, эм, техникийн болон бусад ашигт ургамлын газрын доорхи, дээрх биомасс, ургацын хэмжээ, бүтээмж Хадлан, бэлчээрийн ургамалжилтын зураг, түүний тайлбар, геоботаникийн бичиглэл Байгалийн ургамлын экспортын тоо хэмжээ Ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, улаан номд орсон ургамлын жагсаалт, тэдгээрийн экспорт, импорт Ургамал хамгаалал, ургамлын хөнөөлт шавьж, түүний тархац, хогийн ургамлын тархац, тэдгээрийн хор хөнөөл, түүнтэй тэмцсэн ажлын дүн Нэн ховор, унаган буюу үлдвэр ургамлын удмын санг</p>	<p>12-р сарын 20</p>	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ХБОБНГ, Ботаникийн хүрээлэн</p>



6	<p>Амьтан</p> <p>Хамгаалах зорилгоор ургамлыг тарималжуулж, нутагшуулж байгаа мэргэжлийн байгууллагын тоо, ажлын тайлан, судалгааны дүн</p> <p>Ургамлыг гал түймрээс хамгаалах талаар авсан арга хэмжээ</p> <p>Ургамлын өвчлөлийн судалгааны дүн, хамгаалахаар авсан арга хэмжээ</p> <p>Ургамлыг хөнөөлт мэргчид, хортон шавьжаас хамгаалах талаар авсан арга хэмжээ</p> <p>Ургамлыг химийн бодисын хортой нөлөөллөөс хамгаалах, хорио цээр тогтоох талаар авсан арга хэмжээний дүн мэдээ</p> <p>тарималжуулсан байгалийн ургамлын төрөл зүйл, талбай</p> <p>Ургамлыг нь үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан газрын хэмжээ, нөхөн сэргээсэн дүн</p> <p>Үйлдвэрийн зориулалтаар ашигласан ургамлын тоо хэмжээ</p> <p>Судалгаа, шинжилгээний зориулалтаар ашигласан ургамлын тоо, хэмжээ</p> <p>Ахуйн зориулалтаар ашигласан ургамлын тоо, хэмжээ</p> <p>Эмийн ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан тоо, хэмжээ</p> <p>Ургамлын генийн болон эд эсийн цуглуулга, лабораторид хадгалсан үр хөврөл</p> <p>Амьтны аймгийн ангилаг зүй, зүйлийн бүрдэлдэхүүн, тархац нутаг, нягтшил</p> <p>Ан амьтны нөөц, тоо толгой, сүргийн бүтэц, нөхөн үржил, жилийн цэвэр өсөлт, бууралт, амьтны шилжилт хөдөлгөөн</p> <p>Жинд агласан, барьсан болон гадаадад гаргасан амьтны төрөл зүйл, тоо хэмжээ, илрүүлсэн зөрчлийн тоо, хэмжээ</p>	12-р сарын 20	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ХБОВНГ,</p> <p>Биологийн хүрээлэн</p>
---	---	---------------	---

	<p>Ан амьтны өвчний судалгаа, байгалийн голомтот халдварт өвчний тохиолдол, тархалт, хор хөнөөл</p> <p>Ан амьтны экологи, эдийн засгийн үнэлгээ</p> <p>Амьд амьтны генийн болон эд, эсийн цуглуулга, лабораторид хадгалсан үр хөврөл</p> <p>Амьтан хамгаалах, өсгөн үржүүлэх, нутагшуулах талаар авсан арга хэмжээний дүн, зардал</p> <p>Амьтны аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай конвенц, Улаан номонд орсон амьтдын жагсаалт, тэдгээрийн экспорт, импортын дүн</p> <p>Ан амьтныг хамгаалахад зориулсан биотехникийн арга хэмжээний дүн</p> <p>Агнуурын нөөц, ашиглалт, ан агнуурын нөөц ашигладаг эрх бүхий этгээдийн бүртгэл, төлбөр хураамжийн орлого</p> <p>Амьтны аймгийн амьдрах орчинд гарсан өөрчлөлтийн тухай дүн мэдээ</p> <p>Агаарын үндсэн хийн агууламж, агаар дахь бохирдуулагч бодисын хэмжээ, стандарт болон хүлцэх хэмжээ</p> <p>Агаар бохирдуулагч эх үүсвэрүүдийн тоо, хүчин чадал, ялгарах хүлэмжийн хийн хоногийн хэмжээ</p> <p>Агаарын бохирдлыг хянах цэгийн байршил, тоо</p> <p>Үйлдвэрлэлийн зориулалтаар ашигласан, савласан агаарын хэмжээ</p> <p>Озоны давхаргад хортой нөлөө үзүүлэх бодисын жагсаалт, түүний үйлдвэрлэл, импортын дүн, тоо, хэмжээ</p> <p>Агаар дахь хүлэмжийн хийн агууламж</p> <p>Озоны давхаргын төлөв байдал, нарны хэт ягаан туяаны эрчмийн өөрчлөлтийн хяналт-шинжилгээ</p> <p>Агаар дахь хучиллаг тунадас, цацраг идэвхжилтийн хэмжээний өөрчлөлтийн дүн</p>	12-р сарын 20	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ХВОБНГ, Аймаг нийслэлийн засаг дарга</p>
7	<p>Агаар, түүний бохирдол</p>		

	<p>Агаар, ус, хөрсний бохирдолтоос үүсэх сөрөг нөлөөлөл</p> <p>Орчныг бохирдуулагч нэгжийн талаархи мэдээ, төлбөр</p> <p>Уур амьсгал, цаг агаарын прогност, цаг агаарын төлөв байдлын 7, 10 хоногийн болон сарын урьдчилсан мэдээ</p> <p>Агаар, хөрсний температур, чийгшил, хур тунадаас салхины жилийн дундаж хэмжээ</p> <p>Уур амьсгалын дулаарлын үзүүлэлт, төлөв</p> <p>Цаг агаарын аюултай үзэгдэл, түүний ангилал төрлөөр</p>		<p>Цаг уур орчны шинжилгээний газар</p> <p>ОБЕГ-ын Гамшгаас хамгаалах газрын шуурхай удирдлага зохицуулалтын хэлтэс</p> <p>Аймаг нийслэлийн засаг дарга</p> <p>Цаг уур орчны шинжилгээний газар</p>
<p>8 Уур амьсгал</p>	<p>Байгалийн гамшигт үзэгдлийн төрөл, тодорхойлолт</p> <p>Байгалийн гамшигт үзэгдлийн тохиолдол, давтамж, хамрагдсан нутаг Дэвсгэр</p> <p>Байгалийн гамшигт үзэгдлийн эмзэг байдал, эрсдэлийн үнэлгээ</p> <p>Байгалийн гамшигт үзэгдлийн хор уршиг, хохирол</p> <p>Байгалийн гамшигт үзэгдэлтэй тэмцэхэд зарцуулсан зардал, хөрөнгийн хэмжээ</p>	<p>Тухай бүр</p>	<p>Аймаг нийслэлийн засаг дарга</p> <p>Байгаль орчин ногоон хөгжлийн яам ХБОБНГ</p>
<p>9 Байгалийн гамшиг</p>	<p>Химийн хорт болон аюултай бодисын ангилал</p> <p>Олон улсад болон монгол улсад ашиглахыг хориглосон болон хязгаарласан бодис, тэдгээрийг агуулсан бүтээгдэхүүний жагсаалт, ашиглалтын хүрээ, хорт бодисын нэгж агууламж, хүлцэх хэмжээ</p> <p>Химийн хорт болон аюултай бодисын хор, аюулын лавлах мэдээлэл</p> <p>Монгол улсад ургамал хамгаалал, мал эмнэлэг, ариутгал, халдваргүйтгэлийн зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт</p> <p>Ахуйн хортон шавьж, мэрэгч устгалын зориулалтаар</p>	<p>Тухай бүр</p>	<p>Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, аялал жуулчлал, геологи уул уурхайн хяналтын газар</p> <p>Аймаг нийслэлийн засаг дарга</p>
<p>10 Химийн хорт болон аюултай бодис</p>		<p>12-р сарын 20</p>	

		<p>ашиглаж болох бодисын жагсаалт</p> <p>Химийн хорт болон аюултай бодисын улсын нэгдсэн тоо бүртгэл, тооллогын дүн</p> <p>Химийн хорт болон аюултай бодисын импорт, экспорт, үйлдвэрлэл, худалдаа, тээвэрлэлт, хадгалалт, ашиглалт, устгалын дүн мэдээ</p> <p>Химийн хорт болон аюултай бодистой холбоотой гарсан аюул, ослын тохиолдол, учирсан хор хохирлын хэмжээ</p> <p>Аюултай хог, хаягдлын улсын бүртгэл, дүн мэдээ</p> <p>Хог, хаягдлын ангилал, зайлуулах цэгүүдийн байршил, талбайн хэмжээ</p> <p>Длгарсан ахуйн болон үйлдвэрлэлийн хог, хаягдлын тоо хэмжээ</p> <p>Эмнэлгийн хог, хаягдал зэрэг тусгай ангиллын хог хаягдлын устгалын мэдээ</p> <p>Хогийн цэгүүдэд цуглуулсан, тээвэрлэсэн, зайлуулсан, ангилсан, ашигласан, дарж булсан хог, хаягдлын тоо, хэмжээ.</p> <p>Хог, хаягдлын сангийн бүрдүүлэлт, зарцуулалт, хог, хаягдал гаргасны төлбөрийн орлого</p> <p>Аюултай хог, хаягдлыг экспортлох эрх бүхий иргэн, хуулийн этгээдийн бүртгэл, мэдээ</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн хилийн цэс болон газрын зургийг дархан цаазат, байгалийн цогцолборт, байгалийн нөөц, дурсгалт газрын ангилал</p> <p>Орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутгийн хилийн цэс болон газрын зураг</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн ашиглалтын талаархи тайлан, мэдээ</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс нутгийн газрын зураг</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутаг дахь аялал жуулчлал эрхлэгчдийн тоо, ажлын үзүүлэлт</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутагт явагдсан</p>		
11	Хог хаягдал		12-р сарын 20	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ХЕОБНГ Аймаг, Нийслэлийн засаг дарга
12	Тусгай хамгаалалттай газар нутаг		12-р сарын 20	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ТХНУГ газар Аймаг, Нийслэлийн засаг дарга

	<p>Сүдэлгээ, шинжилгээний ажлын тайлан</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутаг дахь Байгалийн дагалт болонялаг ашиглалт, орлогын мэдээ</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутаг дахь Биологийн төрөл зүйлийн нэр, тархац, нөөц</p> <p>Тусгай хамгаалалттай газарт газар ашиглаж үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл, тусгай зөвшөөрөл, гэрээний дугаар, хугацаа</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутаг дээр хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо, мэдээ</p> <p>Тусгай хамгаалалттай газар нутагт хэрэгжүүлж байгаа менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, шинэчлэлтийн талаархи мэдээ</p> <p>Байгаль орчны холбогдолтой олон улсын гэрээ</p>		
13	<p>Байгаль орчны эрх зүй</p> <p>Байгаль орчны холбогдолтой хууль тогтоомж</p> <p>Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газрын аяллагаас нийтээр дагаж мөрдүүлэхээр гаргасан шийдвэр</p> <p>Байгаль орчны олон улсын болон үндэсний стандарт</p> <p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээний тайлан</p>	Тухай бүр	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ТЗУГ
14	<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ</p> <p>Үнэлгээ хийлгэсэн төслийн товч тодорхойлолт, кадаррын зураг</p> <p>Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хангалт-шинжилгээний хөтөлбөр</p> <p>Байгаль орчны төлөв байдлын үндсэн үзүүлэлтүүд</p> <p>Холбогдох мэргэжлийн хяналт, аудитын байгууллага болон улсын байцаалчаас хийсэн шалгалт, мониторингийн дүн</p> <p>Олон нийт, иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдол</p> <p>Нөхөн сэргээлтийн тайлан, зураг, байршуулсан барьцааны болон зарцуулсан хөрөнгө</p> <p>Байгаль орчны үнэлгээ хийх эрх бүхий мэргэжлийн байгууллагын нэр, хаяг</p> <p>Улсын Их Хурлаар батлагдсан бодлого, хөтөлбөрийн</p>	Тухай бүр	Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ХБОБНГ

15	<p>Байгаль орчны бодлого хөтөлбөрийн хэрэгжилт</p>	<p>жагсаалт, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах нэгж хамрах хүрээ, хэрэгжилтийн түвшин</p> <p>Засгийн газраар батлагдсан бодлого, хөтөлбөрийн жагсаалт, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах нэгж хамрах хүрээ, хэрэгжилтийн түвшин</p> <p>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, байгаль орчны асуудлаар дэвшүүлсэн зорилт, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, нэгж хамрах хүрээ, хэрэгжилтийн түвшин</p> <p>Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болон Засгийн газрын агентлагийн үйл ажиллагааны стратеги, бүтцийн хөтөлбөр, түүний хэрэгжилтийн түвшин</p> <p>Байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлж байгаа олон улсын төслийн нэр, хэрэгжилтийн хугацаа, хэрэгжүүлэгч нэгж, хамрах хүрээ, явц, үр дүн</p> <p>Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал</p>	<p>Тухай бүр</p> <p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яам БХЭГ</p>
16	<p>Байгаль орчны статистик мэдээлэл, тайлан</p>	<p>Байгалийн нөөцийн статистик үзүүлэлт</p> <p>Орчны бохирдлын статистик үзүүлэлт</p> <p>Байгаль орчны төлөв байдлын өөрчлөлтийн статистик</p> <p>Байгаль орчны чиглэлээр тухайн жилд улсын төсвөөс санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалтын дүн</p> <p>Олон улсын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгийн зарцуулалт</p> <p>Орон нутгийн төсвөөс байгаль орчинд зарцуулсан хөрөнгийн зарцуулалт</p> <p>Иргэн, хуулийн этгээдийн байгаль орчны зориулалтаар зарцуулсан төсөв, хөрөнгийн зарцуулалт</p> <p>Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардал, төсвийн дүн мэдээ</p>	<p>Тухай бүр</p> <p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны тухайн асуудал эрхэлсэн газар, хэлтэс</p>
17	<p>Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардал</p>	<p>Тухай бүр</p>	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яам Санхүү хөрөнгө оруулалтын хэлтэс</p>
18	<p>Байгаль орчны чиглэлээр үйл</p>	<p>Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллага, хүний нөөц</p> <p>Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эрдэм шинжилгээний байгууллага, хүний нөөц</p>	<p>Тухай бүр</p> <p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ТЗУГ</p>

<p>ажиллагаа явуулж Байгаа Байгууллага, хүний нөөц</p>	<p>Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллага, хүний нөөц Байгаль орчин, үнэлгээний болон мэргэжлийн байгууллагын эрх авсан аж ахуйн нэгж, байгууллага, хүний нөөц Байгаль орчны тодорхой асуудал хариуцан ажилладаг зөвлөл, хүний нөөц Байгаль орчны чиглэлээр сургалт эрхэлдэг их, дээд сургууль, коллеж, хүний нөөц Байгаль орчны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулж байгаа нөхөрлөл, хүний нөөц Мэдээллийн нэр, товч тайлбар Мэдээллийн чанарын тодорхойлолт Мэдээллийн үндсэн эх сурвалж Мэдээллийн тойм дүрсэлэл, солбицлыгын тогтолцоо Мэдээллийн хэрэглээ, түгээлт</p>		
<p>19 Мета мэдээлэл</p>	<p>Байгаль орчинд хохирол учруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухай мэдээлэл Байгаль орчинд учруулсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, ноогдуулсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр төлсөн, хохирлыг арилгасан тухай тайлан</p>	<p>Тухай бүр</p>	<p>Байгаль орчны мэдээллийн төв</p>
<p>20 Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөрийн Мэдээлэл</p>	<p>Байгаль орчинд хохирол учруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын тухай мэдээлэл Байгаль орчинд учруулсан хохирлын экологи-эдийн засгийн үнэлгээ, ноогдуулсан хохирлын нөхөн төлбөрийн хэмжээ Байгаль орчинд учруулсан хохирлын нөхөн төлбөр төлсөн, хохирлыг арилгасан тухай тайлан</p>	<p>Тухай бүр</p>	<p>Татварын ерөнхий газар Аймаг нийслэлийн засаг дарга</p>
<p>21</p>	<p>Байгаль орчны холбогдолтой гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэл</p>	<p>Тухай бүр</p>	<p>Эрүүгийн цагдаагийн газрын Байгаль орчны салбарт үйлдэгдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс</p>
<p>22</p>	<p>Байгаль орчны талаархи бусад мэдээлэл</p>	<p>Тухай бүр</p>	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яам ТЗУГ</p>